



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/353

Мандалговь

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж
буй иргэдэд сургалт зохион байгуулах
тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 30 дугаар зүйлийн 30, 30.2, 30.3 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хааж журам"-ын 4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 4.2, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн 14 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн штабын "Сургалтын төлөвлөгөө"-ний дагуу цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж буй иргэдийг зарлан дуудаж "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл", "Тусгай үүргийн бэлтгэл" сургалтыг Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын материаллаг баазыг түшиглэн 2021 оны 9 дүгээр сарын 12-наас 9 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаатайгаар зохион байгуулсугай.

2. Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний хоолны зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 286 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын дагуу хүнсний хангамжийн хоногийн хэмжээг 20 хүнээр тооцож, нэгдүгээр хавсралтаар хүнс, хоёрдугаар хавсралтаар сургалтад шаардагдах бусад зардлыг тус тус баталсугай.

3. Сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулж явуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх), орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер (дэд хурандаа Ц.Баттулга) нарт даалгасугай.

4. Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг үндэслэн цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийг аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж, Коронавирус /Covid-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

5. Цэргийн албыг дүйцүүлэн хааж байгаа иргэдийн сургалтын зардалд шаардагдах 3,358,480 (гурван сая гурван зуун тавин найман мянга дөрвөн зуун ная) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор)-д нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210457